



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/36

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.б, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүрд сумын нутаг дэвсгэр дэх “Тарнын гүүрний хяналтын цэг”-т хяналт тавьж, халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдээс түргэвчилсэн оношлуураар (PCR) шинжилгээ авч, бүртгэл судалгааг тухай бүр хийж ажиллах төрийн албан хаагчдын багийн бүрэлдэхүүнийг 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажиллуулсугай.

2.Дээрх хяналтын цэгт ажиллах албан хаагчдын үйл ажиллагаа, илүү цагийн урамшуулалд шаардагдах зардал 11,416,500 (арван нэгэн сая дөрвөн зуун арван зургаан мянга таван зуу) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Хяналтын постонд ажиллах албан хаагчдын ажил үүргийн хуваарийг баталж, халдвар хамгааллын дэглэм хангуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), хяналт тавьж, хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), сумын Засаг дарга нар, аймгийн Онцгой комиссын шуурхай штабт тус тус үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100084

Аймгийн Засаг даргын 2021 оны...
дугаар сарын...-ны өдрийн ... дүгээр
захирамжийн хавсралт



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН ТАРНЫН
ПОСТЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

| № | Шаардагдах хэрэгсэл | Тоо, хэмжээ /ширхэг / | Нэг бүрийн үнэ, мян/төг/ | Нийт үнэ / мян/төг | Тайлбар |
|-------------------------------------|---|---------------------------------------|--------------------------|--------------------|------------------------------|
| 1.Хөдөлмөр хамгааллын хувцас | | | | | |
| 1.1 | Маск | 1650 | | | Эрүүл мэндийн газраас хангах |
| 1.2 | Нүүрний хаалт | 400 | | | |
| 1.3 | Бээлий | 4000 | | | |
| 1.4 | санитол | 40 | | | |
| 1.5 | комбинзон | 330 | | | |
| 1.6 | Улавч | 400 | | | |
| 1.7 | N95 маск | 198 | | | |
| 1.8 | нүдний шил | 198 | | | |
| 1.9 | малгай | 1650 | | | |
| | Бүгд | 8866 | | | |
| 2. Үйл ажиллагааны зардал | | | | | |
| 2.1 | Хоол | 8хүн /33 хоног | 5000 | 3960 | |
| 2.2 | Түлш / нүүрс | 1 портер | 250 | 250 | |
| 2.3 | Түлш/ мод | 20ш- 7хоногт- 100шуудай | 6000 | 600 | |
| 2.4 | дата- модем | 1 | 300 | 300 | |
| 2.5 | ШТС-ын зардал - ээлж солилцох/ | 250л | 1450 | 362.5 | |
| 2.6 | Цэвэрлэгээний бодис / угаалгын нунтаг, гарын саван/ | 1 | 50 | 50 | |
| 2.7 | Цайны материал | 1 | 150 | 150 | |
| 2.8 | Цахилгааны утас | 120м | 2200 | 264 | |
| 2.9 | Уртасгагч | 4ш | 20 | 80 | |
| 2.10 | Самбар /хулдаасан/ | 4 | 30 | 120 | |
| | Бүгд | | | 6156.5 | |
| 3. Илүү цагийн урамшуулал | | | | | |
| 3.1 | Албан хаагч | 1 өдөрт – 8 албан хаагч /33 хоног/ | 20 | 5280 | |
| | Нийт | | | 11.416.5 | |